

ЗАСГИЙН ГАЗРААС БАТАЛСАН
“АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН

/2009 оны жилийн эцсийн байдлаар/

2010.02.05

Д.д	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл						
1	ЗГ-ын тогтоолын дугаар, огноо		Хөтөлбөрийг Засгийн газрын 2008.07.09-ны өдрийн 288 дугаар тогтоолоор баталсан.						
2	Хөтөлбөр хэрэгжүүлж хугацаа		2008-2016 он						
3	Хөтөлбөрийн зорилго		Хөтөлбөрийн зорилго нь Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд ахуй үйлчилгээний салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, ахуйн үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын түншлэлийг бэхжүүлэх замаар хүний хөгжлийг дэмжих, үйлчилгээний хүртээмж, соёлыг дээшлүүлэхэд оршино.						
4	Хөтөлбөрийн зорилтууд /үе шатаар/	Зорилтууд	Хөтөлбөрийн зорилгыг хангахын тулд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд: а/ ахуйн үйлчилгээний онцлогийг тусгасан салбарын хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх; б/ ахуйн үйлчилгээний салбар дахь хүний хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх; в/ ахуйн үйлчилгээг бодлогоор дэмжиж, санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээг нэвтрүүлэх; г/ үйлчилгээг олон улсын чанар, стандартын түвшинд хүргэх, салбарын хэмжээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.						
5	Зарцуулсан хөрөнгө	Төсөв /шаардагдах нийтзардал/	253.5 сая төгрөг						
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	3464 мянган төгрөг						
		тухайн жилд зарцуулсан	3464 мянган төгрөг						
6	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Нийт	70	50	30	10	0	Дундаж
		2009-2012 оны зорилт	4			2(1,2)	1(3)	1(4)	20%
7	Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> - ахуйн үйлчилгээ эрхлэх эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ; - ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж, ажилгүйдэл, ядуурал буурч, амьдралын түвшин дээшилнэ; - ахуйн үйлчилгээний чанар сайжирч, хүртээмж, нэр төрөл нэмэгдэнэ; - ажиллагсдын ур чадвар, өрсөлдөх чадвар дээшилнэ. 							
	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл						
		- Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд дэвшүүлсэн ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого болон	Суурь үзүүлэлт: Ахуйн үйлчилгээний салбарт нийт 219 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 1200 гаруй хүнийг ажлын байраар хангаж						

		<p>боловсрол, хүний хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүнгийн тайлан, түүнд хийсэн шинжилгээ;</p> <p>- ахуйн үйлчилгээ эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, түүний үр нөлөө, мэдээ, мэдээлэл дамжуулах төвийн тоо, тэдгээрийн үр дүн, төрийн бус байгууллага, иргэдийн оролцооны өсөлт;</p> <p>- ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн тоо болон тэдгээрийн үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, түүний өсөлт, хөгжлийн сан, арилжааны банкнаас олгосон зээл, түүний үр дүн, гадаадын зээл, тусламжийн өсөлт, түүний үр дүн, шинээр бий болгосон ажлын байрны тоо.</p>	<p>байна. Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбооноос 2007 онд хийсэн судалгаанаас үзэхэд ахуйн үйлчилгээний салбарт 60 гаруй мянган хүн ажиллаж байна. Энэ нь ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн 98 хувь нь албан бус хэвшилд хамрагдаж байна.</p>
8	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа	<p>“Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих хөтөлбөр”-ийн 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилт бүхий 36 арга хэмжээ тусгагджээ. Үүнээс 10 арга хэмжээг 2009 онд хэрэгжүүлэх эхлэхээр төлөвлөжээ.</p> <p>Ахуйн үйлчилгээний салбарын онцлогийг тусгасан салбарын хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Сайдын Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбоотой байгуулсан ХҮГ-17 тоот гэрээний дагуу ахуйн үйлчилгээний салбарт мөрдөгдөж буй болон шинээр боловсруулах, шинэчлэх стандартуудын судалгаа хийж байна. - “Тэр ахуйн цахилгаан хэрэгслийн засварын газарт тавигдах ерөнхий шаардлага”, “Бильярдын үйлчилгээнд тавигдах шаардлага” стандартын төслүүдийг боловсруулсан. - Нийслэлийн ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих дэд хөтөлбөр боловсруулан, НИТХ-аар батлуулав. <p>Ахуйн үйлчилгээний салбар дахь хүний хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - 2009 оны 6 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Орхон аймгийн Эрдэнэт хотод Төвийн бүсийн хэмжээнд ахуйн үйлчилгээний жишиг цогцолбор төвийн үзүүлэх сургалтыг зохион байгуулав. Уг сургалтад Дархан-Уул, Төв, Булган, Сэлэнгэ аймгаас төр, захиргаа, хувийн хэвшлийн нийт 50 төлөөлөгч оролцов. - Монгол Улсын ахуйн үйлчилгээний “Мастер үсчин”, “Мастер гоо засалч” шалгаруулах ажлыг Монголын үйлдвэрлэлийн хоршооллын төв холбоо, Монголын үсчин, гоо засалчдын холбоо, Монголын үсчин, гоо засалчдын мэргэжлийн холбоотой хамтран 2009 оны 12 сард зохион байгуулж, комиссын дүгнэлтийг үндэслэн шалгуур хангасан ажилтнуудад Сайдын 2009 оны 283 тоот тушаалаар “Мастер” цол, гэрчилгээ олгов. <p>Ахуйн үйлчилгээг бодлогоор дэмжиж, санхүүгийн төрөл бүрийн</p>	

		<p>үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд: - 2009 онд ЖДҮ-лэл эрхлэгчдэд олгосон хөнгөлөлттэй зээлд ахуйн үйлчилгээний 361 төсөл дэмжлэг авчээ.</p>
9	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтын үр дүнд, үр ашиг, үр өгөөж/	<p>Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг удирдлага болгож ХҮБХЗГ-аас гаргасан уг хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, холбогдох статистик мэдээллүүдийг үндэслэн хийв.</p> <p>Хөтөлбөрийг 2009-2012 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний арга хэмжээ 2009 оны жилийн эцсийн байдлаар 20 хувийн биелэлттэй хэрэгжиж байна.</p> <p>Хөтөлбөрийн Үндэсний зөвлөлийг ХХААХҮ-ийн сайдын 2009 оны 222 тоот тушаалаар батлуулан, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл, 2010 оны төсөвт хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгийг зарцуулах хуваарийг боловсруулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажил эхэлж байна.</p> <p>Салбарын хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ төлөвлөлтийн шатанд хэрэгжиж байна. Аймгуудад ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх талаар аймгийн ХХААЖДҮГ-уудтай хамтран ажиллаж удирдамж, зөвлөмжөөр хангах нь чухал.</p> <p>Салбарт мөрдөгдөж буй стандартыг шинэчлэх арга хэмжээг эрчимжүүлэх, ахуйн үйлчилгээний жишиг цогцолбор төвд тавигдах шаардлагыг нэн түрүүн боловсруулах зүйтэй.</p> <p>Ахуйн үйлчилгээний салбар дахь хүний хөгжлийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд 2009 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 арга хэмжээний биелэлт сайн байна. Салбарын нэгдсэн мэдээллийн нэгдсэн санг байгуулах арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй байна.</p> <p>2009 онд ЖДҮ эрхлэгчдэд олгосон хөнгөлөлттэй зээлд ахуйн үйлчилгээ эрхлэгч 361 төсөл хамрагджээ. Зээлийн баталгааны сан, ахуйн үйлчилгээ хөгжүүлэх дундын санг бий болгох, санхүүгийн түрээс, даатгал зэрэг санхүүгийн бусад үйлчилгээнд хамруулах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүргэх талаар идэвхтэй ажиллах шаардлагатай.</p> <p>Хөтөлбөрийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг нь тогтмолжуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодотгох, хэрэгжилтийг хангахад шаардагдах санхүүжилтийг цаг тухайд нь шийдвэрлүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх нь чухал байна.</p>
10	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр хугацаандаа олгогдохгүй байгаагаас хамаарч хөтөлбөрийн зарим арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байна.</p>
11	Эдгээрээс гарах арга зам	<p>- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг батлуулах, - Салбарын хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, зээлийн баталгааны сан, ахуйн үйлчилгээ хөгжүүлэх дундын санг бий болгох, санхүүгийн түрээс, даатгал зэрэг санхүүгийн бусад үйлчилгээнд хамруулах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүргэх, - Аймгуудад ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, ЖДҮ дэмжих хөнгөлөлттэй зээлд ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг хамруулах талаар аймгийн ХХААЖДҮГ-уудтай хамтран ажиллаж удирдамж, зөвлөмжөөр хангах, - Хөтөлбөрийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг нь тогтмолжуулах,</p>

		хөтөлбөрийн үе шатны зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний арга хэмжээ бүрийн оны хуваарилалт, үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодотгох, хэрэгжилтийг хангахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тухай бүр шийвэрлүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх,
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	Энэ хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгуудын ХХААЖДҮГ-тай хамтран ажиллах, банк санхүү, эрдэм шинжилгээ, төрийн бус байгууллага, хоршоод, их дээд сургуулийн хамтын ажиллагааг улам сайжруулах.
13	Хөтөлбөрийн талаархи яамны санал	Хөтөлбөрийг хэрэгжилтэнд шаардагдах санхүүжилтийг цаг хугацаанд гаргуулах асуудлыг Сангийн яам, Засгийн газарт оруулан дэмжлэг авах.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА